



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 09 сарын 18 -ны өдөр

Дугаар А/92

Эрдэнэт

Ажлын хэсэг томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого батлах тухай" Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь

1. Аймгийн "Эрүүл мэндийн байгууллагын хөгжлийн төлөвлөгөө"-г боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Эрүүл мэндийн газрын дарга

Гишүүд:

ЭМГ-ын Яаралтай гамшгийн үеийн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
ЭМГ-ын Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
ЭМГ-ын Сувилахуй, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
ЭМГ-ын Хүний нөөцийн төлөвлөлт хангалт сургалт мэргэжлийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн
ЭМГ-ын Эх, хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төвийн Захирал
Өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбооны тэргүүн
Эрдэнэт сувиллын цогцолборын Үйл ажиллагаа хариуцсан орлогч
Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн дарга
Хувийн хэвшлийн Чандмань-Эрдэнэ холбооны тэргүүн
Клиникүүдийн холбооны тэргүүн

Нарийн бичиг: ЭМГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

2. "Эрүүл мэндийн байгууллагын хөгжлийн төлөвлөгөө"-г боловсруулан батлуулж, хэрэгжүүлж ажиллахыг Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

Илтгэл хэлэлцүүлэх хуваарь

2020.09.17

№	Эрүүл мэндийн байгууллага	Хугацаа	Хариуцах
1	Эрдэнэт сувиллын цогцолбор	2020.09.28 14.00 цаг	Эрдэнэт сувиллын цогцолборын Үйл ажиллагаа эрхэлсэн орлогч Ж.Ганчимэг
2	Сумын эрүүл мэндийн төв	2020.09.29 09.00 цаг	СЭМТ-ийн дарга Ч.Дэлгэрмаа
3	ӨАУМ-ний холбоо	2020.09.30 14.00 цаг	ӨАУМХолбооны Б.Жаргалсайхан
4	Эм холбоо	2020.10.01 10.00 цаг	Эм холбооны Б.Баасанбат
5	ХХЭМБ-ын Чандмань-Эрдэнэ холбоо	2020.10.01 14.00 цаг	ХХЭМБ-ын Чандмань-Эрдэнэ холбооны тэргүүн С.Гүнчинсүрэн
6	Медипас төв эмнэлэг	2020.10.02 10.00 цаг	Медипас төв эмнэлгийн захирал Я.Энхчулуун
7	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	2020.10.02 14.00 цаг	БОЭТ-ийн захирал Б.Батсүх

Илтгэлд тавигдах шаардлага:

1. Илтгэл тавих хугацаа 15-20 минут байна.
2. Илтгэлийн текстийг Times New Roman эсвэл Arial-ын 11-12 үсгийн фонтоор мөр хооронд 2.0 зайтай бичих /дүрслэл, зураг оруулна/

Илтгэлийн чиглэл

1. Байгууллагын өнөөгийн байдал
2. Тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх боломж
3. 2020-2022 оны эрүүл мэндийн салбарын хөгжлийн төлөвлөгөөнд тусгах ажлыг эрэмблэх
 - Тусламж үйлчилгээг сайжруулах менежмент /удирдлага, зохион байгуулалт, манлайлал, байгууллагын соёл, салбар дундын хамтын ажиллагаа, уялдаа, шинээр нэгж үүсгэх хэрэгцээ/
 - Тусламж үйлчилгээнд шинээр нэвтрүүлж нутагшуулах дэвшилтэт технологи
 - Тусламж үйлчилгээний хүртээмж, ачааллыг бууруулах, иргэдийн хүлээгдэл чирэгдлийг багасгах, төвлөрлийг сааруулах чиглэлээр хийх ажил
 - Хөрөнгө оруулалт, санхүүжилт, хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр
 - Дээрх үйл ажиллагаа хэрэгжүүлснээр хүрэх түвшин

2020-2022 оны эрүүл мэндийн байгууллагын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа дараах бодлогын баримт бичигтэй танилцсан байна. Үүнд:

- Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр / Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоол/
- "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлого /Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол/
- Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, 2017-2026 он /ЗГ-ын 2017 оны 24 дүгээр тогтоол/
- Аймгийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, 2017-2026 он /ИТХ-ын 2017 оны 6/03-р тогтоол/
- Тухайн эрүүл мэндийн байгууллагын стратеги төлөвлөгөө

PPT-ийн слайдуудыг хувилж хуралд оролцогчдод тарааж өгч болно.